

# УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

## МОНГОЛ ХЭЛ

### XII АНГИ

Аймаг/дүүрэг: .....

Сум: .....

Сургууль: .....

Анги: ..... Бүлэг: .....

Овог: .....

Нэр: .....

#### САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

## Хүн (эсээ)

Намайг бага байхад нутгийн өвгөд хэн нэгнийг "Энэ хүн болно" гэх, эсвэл "Тэр хүн болсонгүй", бүр эсвэл "Тэр хүн биш", заримдаа "Тэр хүний дээд" гэж ярихыг олонтоо сонсож би юу хэлээд байгааг нь сайн ойлгохгүй ихэд гайхдаг байж билээ. Тэдний яриад буй хүмүүсийг харахад бүгд л толгойтой, нүдтэй, хамартай, амтай, гартай, хөлтэй, хэлтэй, яриатай хүнтэй адил хүн байх аж. Тэгтэл тэдний хэн нэгэн "Хүн" болж, нөгөө нь "Хүн биш" болдог. Хачин л санагддаг сан. "Нэгэнт хүн төрсөн юм чинь хүн л болохоос өөр амьтан болохгүй шүү дээ". Ингэж бодож бас инээд хүрч байсан үе ч бий. Гэвч ардын үг гэдэг гүн утгатай.

Миний хувьд "ХҮН" гэдэг үгийг ямагт том үсгээр бичмээр санагддаг юм. Учир нь орчлон ертөнцөд ухаант хүн л буй болж байж сая амьдрал гэгч үүссэн буй заа. Хүн буй болоод гал эзэмшиж, мал адгуус гаршуулж, газар тариалан эрхэлж, хот тосгон байгуулж, урлагийн гайхамшигт бүтээл туурвиж, шинжлэх ухааны шинэ нээлт хийж, чухамхүү энэ орчлонг улам чимж, сайхан, утга учиртай болгосон бус уу? Гэтэл хүн болгон тийн амьдарч, бүтээж, хүн хүндээ тус болж, хайрлаж чаддаггүй байна. Иймээс бусдын тусын тулд сайн үг хэлж, сайн зүйл бүтээж, олон түмэнд тус болж, өгөөмөр сайхан сэтгэл гаргаж буй хүнийг "хүн" гэж ярьж, харин үүний эсрэг үйлтэй хүнийг "хүн биш" гэж ярьдгийг өнөө насанд хүрсэн, ухаан орсон хэн боловч ойлгоно. "Хүн болох багаасаа" энэ үг юутай үнэн. Багаасаа амьдралын үнэнийг ухаарсан зөв үзэл бодолтой, хугас өдрийн өл, нэг шөнийн нойр, өдрийн ажлын ачааллыг даах сэтгэлийн тэнхээ, үгийн хатууг өнгөрөөх ухааны тэвчээртэй өсөж, бусдын ажлын амжилт, амьдралын сайн сайханд үл атаархан, хар амиа бодохгүй, шунал, хов, жив, хэрүүл, хараалаас ангид байж сурна гэдэг хүн болсны хамгийн наад захын шинж. Ер нь хүнийг танихын тулд удам судрыг нь сайн харж, судлах ёстой гэж манай ухаант өвгөд ярьдаг. Үр хүүхдээ удам сайтай айлаас гэрлүүлж, удам сайн айлд мордуулдаг. Тэдний дундаас төрсөн хүүхэд мөн сайн хүн болно гэж үздэг. Ийм ч байсан. Тэгж нүүдэлчин монгол түмэн чанарыг дээдэлж, ёс зан заншлаа он цагийн давиргаанд гээлгүй өнөөгийн хүн төрөлхтний соёл иргэншилтэй хөл нийлүүлж явна.

Би энэ амьдралдаа өөрийнхөөрөө ажигласан "хүн болсон", бас "хүн болоогүй" хүмүүсийн тухай зарим нэг жишээ татъя. Намайг бага байхад манайхтай саахалт зайтай умгар хар гэртэй, өтөл эмээ, ээжтэйгээ амьдардаг, өнчин таван хүүхэд байлаа. Эмээ, эх нь ажилгүй. Хүүхдүүдийн томоос бусад нь арван жилийн сургуульд сурна. Сурагчдын хамгийн том нь есдүгээр анги, бага нь дүүтэй минь чацуу, дөнгөж нэгдүгээр анги. Ес, наймдугаар ангийн хоёр ах нь зуны амралтаар барилгад засвар, тоосгон заводод ажиллана. Гэртээ жилийн дөрвөн улиралд хар цай ууцгааж, ямар ч тосгүй, бараг зуухны таг дээр шууд түлсэн гурил иднэ. Орой голдуу цувдайтай бантан хийнэ. Энэ байдлыг хараад би тэднийг учир мэдэхгүй байхдаа шоолж, ухаан орохын хэрээр өрөвдөж явсан ч тэд энэ байдалдаа огт гутардаггүй, харин ч зүдэртлээ ажил хийж, ажлын хөлсөөр худалдаж авсан хувцас хунараа яаж цэвэрхэн өмсдөг, хичээлийнхээ ном дэвтрийг ямар гамтай хэрэглэдэг зэргийг хараад бахархах сэтгэл төрдөг сөн. Тэд, бүгд онц сурч, сургуулиа сайн төгсөж, чухамхүү өөрийн хөдөлмөр зүтгэлээрээ төрийн сайд хүртэл алба хашиж, өнөөдөр сайхныг үзэж явна. Бүгд «Хүний дээд болов».

Гэтэл багаасаа ийн хүмүүжээгүй, амьдралыг хялбар, бэлэнчлэх сэтгэлгээгээр төсөөлж өссөн хүүхэд тэр бүр "хүн" болж чаддаггүйг их ухаант өвгөд гярхай ажигласан байх юм. Миний оюутан ахуйн нэгэн найзын эцэг нутаг усандаа төдийгүй, улсдаа нэртэй дарга байж, ганц хүүгээ юугаар ч дутаалгүй өсгөж, гадаадад дээд сургууль төгсөх хүртэл нь бараг дагаж явсан билээ. Хүү нь сургууль төгссөн ч, тийм ч сайн сурч байсангүй. Авгай, хүүхэн, бор дарс шүтэх нь түлхүү байлаа. Мөн л сайн эцгийн нэр, нүүрээр сайхан ажилтай болсон ч олон жил ажиллаж чадсангүй. Мань эр тэгсхийгээд л бор дарсанд гүн

автаж, хань, төрсөн хүүхдүүдээ орхин одож, удалгүй ажлаасаа ч гулрах нь тэр. Тэгтэл уул мэт эцэг нь гэнэт "нурав". Эцэг, хүүгийнхээ ухааны ядуугийн энг даагаагүй болов уу, хөөрхий. Хүү эцгийн үлдээсэн буянаар нэг хэсэг наргив. Их далай ч ширгэдэг жамтай. Хүү эцгийн буян үгүй болоход гудамжинд гарав. Одоо дал хол давсан өтөл эхийн тэтгэврийн хэдэн төгрөг буухыг нь андахгүй ирж авдаг гэсэн. Тийм ээ, сайн эцгийн хүү сайн хүн, тэр бүү хэл бүр "Хүн болж чадсангүй" гэж хэлбэл "Үгүй" гэх хүн цөөхөн байх болов уу?

Ийнхүү өндөр боловсрол эзэмшлээ ч уулаасаа "хүн" болж хүмүүжиж чадаагүй, амьдралын өчүүхэн төдий даваа, нугачаанд сөхрөөд өгдгийн нэгэн жишээ энэ ажгуу. Тэгэхээр бэлэнчлэх сэтгэлгээтэй, биеийн амрыг харсан, хүний хорвоод үдлээд өнгөрөх нэг насаа зугаа цэнгэл болгосон бол тэр мөхөж буй хэрэг. Ийм нэгэн "Хүн" гэж үү? Хүн нь хүн боловч "Хүн болоогүй" гэсэн үг. Ай, юутай харуусалтай. Ухаант өвгөд дээдсийн маань "Тэр хүн шүү" гэх, эсвэл "Тэр хүн биш" гэж хэлдэг үг ийм учиртай ажгуу.

Орчлонд хүмүүн болж төрөх нь их хувь заяа гэдэг. Аяга арвай будааг асгахад зүүний үзүүр дээр тогтож үлдсэн нэг ширхэгтэй адилтгадаг юм гэнэ лээ. Тэгэхлээр ийм хувь заяанд төрсөн хүмүүн нэг насны амьдралаа утга учиртай, цагаан мөртэй, сайн нэртэй туулах нь өөрийгөө үнэлэх хамгийн дээд шагнал бус уу? Тийм ээ, "ХҮН" гэдэг үгийг ямагт том үсгээр бичмээр санагддаг юм.

*Х.Хангайсайхан*

**Даалгавар 1.** Эхийг бүтцээр нь зөв зааглан ялгаж, хэсэг бүрд өгүүлэгдэж буй агуулгаар нэр өгөөрэй. (2 оноо)

Эхлэл хэсэг: .....

.....

.....

.....

Гол хэсэг: .....

.....

.....

.....

Төгсгөл хэсэг: .....

.....

.....

.....

**Даалгавар 2.** Эхээс нийгмийн болон соёлын хам сэдвийн жишээ нэг нэгийг олж бичээрэй. (2 оноо)

Нийгмийн хам сэдэв: .....

.....

.....

.....

.....

Соёлын хам сэдэв: .....

.....

.....

.....

.....

**Даалгавар 3.** Эхэд ямар асуудлыг гол болгон хөндсөн байна вэ? Тэрхүү асуудлаа чухал гэдгийг ямар баримтуудаар баталсан байна вэ? (3 оноо)

Асуудал

Баримт

.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....
.....	.....

**Даалгавар 4.** Эхээс гол санааг илэрхийлж буй өгүүлбэрийг олж бичээд, яагаад гол санаа гэж бодож буйгаа батлан тайлбарлаарай. (3 оноо)

**Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэр:**

.....

.....

.....

**Тайлбар:**

.....

.....

.....

**Даалгавар 5.** Эхэд зохиолч “Миний хувьд “ХҮН” гэдэг үгийг ямагт том үсгээр бичмээр санагддаг юм” гэжээ. Хэрэв чи зохиогчоос эсрэг үзэл бодолтой байвал түүнийгээ ямар баримт ашиглан илэрхийлэх вэ? Чиний сонгосон баримтад хүн итгэж, чамтай санал нэгдэхээр байх хоёр баримтыг бичээрэй. (3 оноо)

**Баримт 1:**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

**Баримт 2:**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....





### **Засагч багш нарт:**

Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7- даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

Шалгалтыг зөвхөн 0, 1, 2, 3 гэх мэт бүхэл оноогоор дүгнэнэ. 0.5, 1,5, 2,5 гэх мэт бутархай оноог ямар ч тохиолдолд өгөхгүй.

### **Оноо өгөх зарчим:**

#### **Даалгавар 1. Нийт 2 оноо**

Эхийн бүтцийг зөв зааглан агуулгыг хангахуйц нэрлэсэн бол 2оноо

Эхийн бүтцийн аль нэг хэсгийг буруу заагласан эсвэл аль нэг хэсэгт оноосон нэр тохиромжгүй бол 1 оноо

Эхийн бүтцийг бүхэлд нь буруу заагласан, хэсгүүдэд оноосон нэршил тохиромжгүй эсвэл даалгаврыг гүйцэтгээгүй бол 0 оноо

#### **Даалгавар 2. Нийт 2 оноо**

Нийгмийн болон соёлын хам сэдвээс нэг нэг жишээ татан бичсэн бол 2 оноо

Нийгмийн болон соёлын хам сэдвээс аль нэгийг нь бичсэн эсвэл хоёул нэг хам сэдвийг илтгэж байвал 1 оноо

Сонгосон хэсэг нь хам сэдэв илтгэхгүй, хамааралгүй зүйл байх эсвэл даалгаврыг гүйцэтгээгүй бол 0 оноо

#### **Даалгавар 3. Нийт 3 оноо**

Эхэд гол болгон дэвшүүлсэн асуудлыг олсон бол 1 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудлыг зөв олоогүй бол 0 оноо

Асуудлыг тодруулахад чухал үүрэгтэй буюу санаагаа баталсан баримт 2 ба түүнээс дээш олж бичсэн бол 2 оноо /баримтууд гэж олон тоо заасан байгааг сурагч анзааран бичсэн байх ёстой/  
Асуудлыг тодруулахад чухал үүрэгтэй буюу санаагаа баталсан баримт нэгийг олж бичсэн бол 1 оноо

Олж бичсэн баримт нь санааг дэмжээгүй, утга, агуулгын зөрөөтэй бол 0 оноо

#### **Даалгавар 4. Нийт 3 оноо**

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон бол 2 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон боловч, өөр өгүүлбэр хамт бичсэн эсвэл цогцолбороор нь авсан бол 1 оноо

Эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж чадаагүй бол 0 оноо

Өөрийн үгээр зөв тайлбарласан бол 1 оноо

Гол санааг буруу тайлбарласан эсвэл сонгосон өгүүлбэртэй хамааралгүй зүйлс бичсэн бол 0 оноо

#### **Даалгавар 5. Нийт 3 оноо**

Сонгосон баримт нь (1) зохиогчийн үзэл бодлын эсрэг байр сууринаас хандсан, (2) шинжлэх ухааны үндэслэлтэй, тодорхой эх сурвалжтай, (3) үнэн зөв, ёс зүйн болон оюуны өмчийн зөрчилгүй бол 3 оноо. (1), (2), (3)-ыг тус бүр 1 оноогоор дүгнэж, аль нэгийг хангаагүй тохиолдолд оноог хасна. Мөн нэг баримт дутуу бичсэн бол 1 оноо хасна.

#### **Даалгавар 6. Нийт 2 оноо**

Хэлцийг дэлгэрүүлсэн өгүүлбэр зөв бүтэцтэй, найруулгын ямар ч алдаагүй бол 1 оноо

Өгүүлбэрт бүтэц найруулгын алдаа гарсан бол 0 оноо

Хэлц өгүүлбэрийг “гэ-, хэмээ-“ холбох үг ашиглан дэлгэрүүлсэн бол 1 оноо

XII ангийн агуулгаар үзэж судалсан “гэ-, хэмээ-“ холбох үгсийг ашиглаагүй бол 0 оноо

#### **Даалгавар 7. Нийт 5 оноо**

0-1 алдаатай хөрвүүлсэн бол 5 оноо

2-3 алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо

4-5 алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо

6-7 алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо

8-9 алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

10 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

**Даалгавар 8. Нийт 20 оноо**

<b>агуулаа</b>	<b>оноо өгөх заавар</b>	<b>ОНОО</b>
Сэдэв ба зорилго	Зорилгоо хангаж бодит шийдэл санал болгож, учир шалтгааны уялдаа холбоотой сайтай бичсэн бол	<b>5</b>
	Учир шалтгааны уялдаа холбоо бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч нэгэн сэдвээр бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл хэд хэдэн асуудлыг хөндсөн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Эшлэл баримт	Эшлэл, баримтыг оновчтой ашигласан бол	<b>2</b>
	Тохиромжгүй ч эшлэл, баримттай бол	1
	Эшлэл, баримтгүй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичлэгийн хэлбэр төрөл	Тодорхой хэрэгжүүлж болохуйц бодитой шийдлийг санал болгож байгаа бол	<b>2</b>
	Тодорхой шийдэл санал болгосон ч бодитоор хэрэгжих боломжгүй бол	1
	Ямар нэгэн бодит шийдэл санал болгоогүй, шүүмжийн шинжтэй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	<b>3</b>
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй	<b>3</b>
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Үгийн тоо	250-280 хооронд бол	<b>1</b>
	Үгийн тоо их, бага бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	<b>3</b>
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	<b>1</b>
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	<i>хийгээгүй бол</i>	X